

**Увс аймгийн Түргэн сумын нутагт байрлах Дэглий Цагаан нисэх буудал
шатахууны агуулах төслийн Байгаль орчин менежментийн төлөвлөгөөний
2024 оны хэрэгжилт**

Регистерийн дугаар 2628546

Баталсан; Дэглий цагаан нисэх буудлын дарга.....Л.Энхтуяа

Боловсруулсан; Холбоо навигацын инженер..... С.Баасанжав

2024 он

ГАРЧИГ

1. Товчилсон үгийн тайлбар.
2. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний зорилго.
3. Дэглий цагаан нисэх буудлын үйл ажиллагаа хүчин чадал.
4. Төслийн товч танилцуулга.
5. Төслийн талбай, байршил.
6. Газар ашиглалт.
7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт.
8. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилт.
9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилт.
10. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний 2024 хэрэгжилт.
11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилт.
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт.

Товчилсон үгийн тайлбар

ААНБ- Аж ахуйн нэгж байгуулга

ХБХЗ-Хөөрч буух, хөөрөх хөөрөх зурвас

БОТБУ-Байгаль орчны төлөв байдлын тайлан

БОНБЕУ-Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ

БОННУ-Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

БОНХС-Байгаль орчны ногоон хөгжлийн сайд

БОМТ-Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БОАЖС-Байгаль орчин аялал жуулчлалын сайд

ТХГН-Тусгай хамгаалалттай газар нутаг

ЗТБХБ-Зам, тээвэр барилга хот байгуулалт

ИНЕГ-Иргэний нисэхийн ерөнхий газар

ИНХ-Иргэдийн нийтийн хурал

ГХГЗЗГ-Газрын харилцаа геодези, зураг зүйн зураг

МУ-Монгол улс

УЦУОШГ-Ус цаг уур орчин шинжилгээний газар

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хөрөгжих нутаг дэвсгэрийн байгаль орчиныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нарийвчилсан үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаварыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой. БОМТ-г хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч дараах бодлогыг баримтална. БОМТ нь төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй

- уялдсан байх. БОМТ –ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон оршин суугчидын зүгээс
- хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүн хүрэх. БОМТ –г хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад
- тэсвэртэй байх зэрэг болно

Дэглий Цагаан нисэх буудлын үйл ажиллагаа, хүчин чадал

Тус нисэх буудлыг 1958 оны 04-р сарын 25-нд БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 112 –р тогтоолоор иргэний зориулалтын нислэг үйлдэх чиглэлүүдийг тогтоож тогтмол нислэг үйлдэж эхэлсний нэг нь Увс аймгийн Дэглий Цагаан нисэх буудал байсан. Дэглий Цагаан нисэх буудлын барилгын цогцолбор, агаарын хөлөг хөөрч буух хатуу хучилттай зурвасыг 2011 оны 06-р сарын 25-аас ашиглаж эхэлсэн ба цагт 100 хүнд үйлчлэх хүчин чадалтай тус нисэх буудал нь Ховд, Баян-Өлгий аймгуудын бэлтгэл аэродромын үүрэг гүйцэтгэдэг. Нисэх буудал нь нислэгийн аюулгүй байдал , аюулгүй ажиллагааг хангаж, авиа компаниудад найдвартай , зорчигчидод соёлтой шуурхай үйлчилхэд бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Нисэх буудал нь дараах үйлчилгээнүүдийг үзүүлдэг;

1. Нислэгийн удирдлага.
2. Холбоо навигаци.
3. Агаарын хөлгийн газрын техник үзлэг, удирдлага.
4. Агаарын хөлгийн шатахуун хадгалалт, лаборатори оншилгоо, сумалгаа.
5. Авран хамгаалах, гал унтраах.
6. Аюулгүй байдлын үзлэг.
7. Ачаа тээшийн үйлчилгээ.


Дэглий Цагаан нисэх буудал нь ЗС ангилалд хамаарах 2-р зэрэглэлийн нисэх буудал бөгөөд одоогийн байдлаар нийт 35 ажиллагсадтай хэдий ч жишиг орон тоо нь 28 гэж тодорхойлсон байна. Монгол улсын УИХ-ын 2013-оны 02-р сарын 07-ны өдрийн 18-р тогтоолоор баталсан төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын хүрээнд “Дэглий Цагаан” нисэх буудлыг цагт 300 зорчигчидод үйлчлэх хүчин чадалтай болгон өргөтгөх зорилготой инженерийн барилга байгууламжын зураг төслийг боловсруулах ажлыг гүйцэтгэж эхэлсэнээр тус нисэх буудал нь аэродромын хяналтаар 4с ангилалд шилжинэ

1. төслийн товч танилцуулага

1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл

Төслийн нэр: “Дэглий цагаан” нисэх буудал
Төсөл хэрэгжүүлэгч: ИНЕГ Төрийн өмчит Увс аймаг дахь салбар
Улсын бүртгэлийн дугаар 9013001003
ААНБ-ын регистрийн дугаар 2628546
Салбарын гэрчилгээний дугаар 000004809
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Увс аймаг Түргэн сум Баянхайрхан баг
Утас: 976-70452550
Майл хаяг: uvs.airport@mcaa.gov.mn
Сайт: <https://www.mcaa.gov.mn/>
Төсөл хэрэгжих газрын орон нутгийн харьяалал: Увс аймгийн Түргэн сум, Баянхайрхан баг,

ИНЕГ Төрийн өмчит Увс аймаг дахь салбар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна. Эрх бүхий этгээд нь Иргэний Нисэхийн Ерөнхий Газар байна.



Зураг 1.2 “Дэглий цагаан” нисэх буудлын бүтэц, зохион байгуулалтын схем

Тус нисэх буудал нь баталсан орон тооны дагуу захиргаа аж ахуй, нислэг хөдөлгөөн аэронавигацийн хэсэг, аэродром ашиглалтын хэсэг, аюулгүй байдлын хэсэг, газрын тусгай үйлчилгээний хэсэг, галын бүлэг гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар ажиллаж нисэхийн аюулгүй байдал аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ажлын зохион байгуулалтыг хийж ажиллаж байна.

2.1 төслийн байршил

The figure consists of three maps of Mongolia. The top-left map is a detailed map of the Gobi Desert region, showing the Gobi Desert, the Gobi-Saigun Desert, and the Gobi-Saigun Desert. It includes a legend with symbols for 'Алслагдсан тос' (Settlements), 'Сүлжмэл тос' (Settlements), 'Нэгдсэн ойролцоо бүсэд' (In the vicinity of the unified area), and 'Алслагдсан тос' (Settlements). The bottom-left map is a map of the Ulaanbaatar region, showing the city of Ulaanbaatar and surrounding areas. The right map is a map of the Dornod region, showing the city of Dornod and surrounding areas. It includes a legend with symbols for 'Алслагдсан тос' (Settlements), 'Сүлжмэл тос' (Settlements), 'Нэгдсэн ойролцоо бүсэд' (In the vicinity of the unified area), and 'Алслагдсан тос' (Settlements). It also includes a scale bar from 0 to 220 Km and a compass rose.

“Дэглий цагаан” нисэх буудлын аэродромын байршлын газар зүйн үзүүлэлтүүд:

- ### 2.1.2. Газар олголт

- Увс аймгийн газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газраас газар ашиглалт, зохион байгуулалтын хяналтын хуудсаар баталгаажуулсан 8520000647 нэгж


талбарын дугаартай газрыг эзэмшлийн эрхээр Түргэн сумын 1 дүгээр багийн нутаг, кадастрын мужийн 200 дахь нэгжид олгосон

- Увс аймгийн Түргэн сумын Засаг даргын 2018 оны 09 дугаар сарын 28-ний өдрийн А/106 тоот шийдвэрээр ИНЕГ ТӨААҮГ-ийн Увс аймаг дахь салбар нь нисэх зурвасын зориулалтаар 13186906м² талбайг 15 жилээр эзэмших эрхийг баталгаажуулж 439773 тоот гэрчилгээ олсон байна.

2.1.3. Газар ашиглалт

Нисэх бүүдлын зориулалтаар эзэмшиж байгаа нийт 131.8 га газрыг дараах байдлаар ашиглаж байна. Үүнд:

- | | |
|--|----------------------|
| • Аэродромын үйлчилгээний барилга байгууламж | 1798 м ² |
| • Хатуу хучилт хийсэн талбай | 125000м ² |
| • Ногоон байгууламж байгуулсан | 660м ² |
| • Шатахууны агуулах | 1960 м ² |



1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ.

1.Ус ашиглах дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулах.

Усны тухай хуулийн 28.4т заасны дагуу Увс аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газарт хүсэлт гаргаж ус ашиглах дүгнэлт гаргуулсан мөн хуулийн 28.6 –д заасны дагуу Түргэн сумын засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл авч мөн хуулийн 19.1.4-д зааснаар Түргэн сумын байгаль хамгаалагчтай ус ашиглах гэрээ байгуулж ус ашиглах эрхээ авч ажилласан.



Нэг.Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 29.1-д зааснаар Увс аймгийн Байгаль орчны газрын 09 дугаартай Ус ашиглуулах дүгнэлт, Сумын Засаг даргын олгоосон 2024 оны ...-р сарын ...-ны өдрийн тоот захирамж /ус ашиглах зөвшөөрл/-ийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Увс аймгийн Түргэн сумын байгаль хамгаалагч
.....

Ус ашиглагчийг төлөөлж: Увс аймаг Түргэн сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Улсын бүртгэлийн тоот гэрчилгээтэй, регистрийн дугаартай "Дэглэй цагаан" нисэх буудлын ажилтан нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 10 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Дулаан үйлдвэрлэл, технологийн хэрэгцээ, ажилтан албан хаагчдын хэрэгцээ, ногоон байгууламж услах, цэвэрлэгээ, зорчигчдын хэрэгцээнд ашиглана.

2.2. Ашиглах усны хэмжээ:

- . Дулаан үйлдвэрлэл, технологийн хэрэгцээнд 34560 м3
- . Ажилтан албан хаагчдын хэрэгцээнд 627,2 м3
- . Ногоон байгууламж услахад 120 м3
- . Цэвэрлэгээнд 5196,8 м3
- . Зорчигчдын хэрэгцээнд 720 м3

2.3. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах усны хэмжээ : Өөрийн эх үүсвэрийн гүний худагаас газрын доорх ус ашиглана.

2.4. Байршил 91° 56' 56.11E 50° 04' 00N

2.5. Байгаль орчны үнэлгээний нөхцөл: Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголыг 2019 онд "ЭХ МОНГОЛЫН БАЙГАЛЬ" ХХК хийж гүйцэтгэсэн.

2.6. Усны нөөц ашигласаны төлбөр: Монгол улсын "Усны тухай хууль", "Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тухай хууль" ийн дагуу 12504 шоо/м үснд оногдуулсан усны нөөцийн төлбөрт 911482 төгрөгийг "Төсвийн тухай" хуулийн 23.6.5-д заасны дагуу Түргэн сумын орон нутгийн орлогод төвлөрүүлэх нь зүйтэй

2.7. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 51/75 тоот хамтарсан тушаалаар баталсан "Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм"-ийг мөрдөж ажиллах

2.8. Ус ашигласны нийт төлбөрийн хэмжээ: 911482 төгрөг /Есөн зуун арван нэгэн мянга дөрвөн зуун наян хоёр төгрөг/

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.3, 13.1.5, 19-р зүйл, 26.1, 29.3, 30.1, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол;

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

 Д.Банди

/Хариуцсан маргажилтан/ Утас: 93007711

Ус ашиглагчийг төлөөлж:

 С.Баасанжав

/Хариуцсан мэргэжилтэн/ Утас: 99936901



УВС АЙМАГ
ТҮРГЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 4/27

Хавцал

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.5 дахь заалт, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Байгаль орчны газрын ус ашиглуулах дүгнэлт, хуульд заагдсан зүйл заалтуудыг үндэслэн "Дэглий цагаан" нисэх буудалд ус ашиглах зөвшөөрлийн гэрээг 10 жилийн хугацаагаар олгосугай.

2."Ус ашиглуулах дүгнэлт"-ээр тогтоогдсон үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах усны нөөцийн төлбөр 911,482 (есөн зуун арван нэгэн мянга дөрвөн зуун наян хоёр мянга) төгрөгийг төсвийн тухай хуульд заасны дагуу Түргэн сумын орон нутгийн орлогод төвлөрүүлж ажиллахыг "Дэглий цагаан" нисэх буудлын дарга (Л.Энхтуяа)-д үүрэг болгосугай.

3.Усны тухай хуульд заасны дагуу ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавих шаардлагыг ханган ажиллаж, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ тайланг дараа оны 1-р улиралд багтаан ирүүлэхийг "Дэглий цагаан" нисэх буудлын дарга (Л.Энхтуяа)-д даалгасугай.

4."Дэглий цагаан" нисэх буудалтай ус ашиглах гэрээ байгуулж усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Байгаль хамгаалагч (Д.Банди)-д үүрэг болгосугай.

Л.БУЯНЖАРГАЛ

Mó: doc:ZahiramjA4

852475031

2.Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт

- 2024 онд зүлэг тэгшлэгч авах төлөвлөгөө батлуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу зүлэг тэгшлэгч авч ногоон байгууламжын өнгө үзэмжийг сайжруулан ажилласан.



Зүлэг тэгшлэж ногоон байгууламжийн өнгө үзэмжийг сайжруулж байна.

- Мөн 2024 онд 15ширхэг голт бор, 15 ширхэг монос, 15ширхэг жигдгний суулгац, 200 ширхэг хайлаас, 3ширхэг мөнх ногоон гацуур суулгаж нисэх буудлын ногоон байгуулжийн өнгө үзэмжийг сайжруулан ажиллаж байна.



Нисэх буудлын авто зогсоол талын голт борын ургасан байдал.



2024 оны 5 сард суулгасан голт бор, моносний суулгац ургаж буй байдал.



2024 оны 5 сард суулгасан хайлаасны суулгац ургаж буй байдал.

Нисэх буудлын авто зогсоол талын 2 торон хашааны дагуу тарьсан.



Мөн 3 ширхэг мөнх ногоон гацуурны суулгац ургаж буй байдал.

3.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилт

- 1.Гал түймэрийн болзошгүй аюул.

Гал түймрийн болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлж нисэх буудлын галын бүлэг Увс аймгийн онцгой байдлын газартай хамтран Дэглий Цагаан нисэх буудлын нийт ажилтан албан хаагчидад **Нисэх буудлын зорчигчидын тэнхимд гарсан гал түймрийг унтраах нь** сэдэвтэй тэнхимийн болон үзүүлэх дадлагажих сургалтыг 2024 оны төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажилласан.

Увс аймаг Онцгой байдлын газар Гал түймэр унтраах, аврах 41 дүгээр анги	
ДЭГЛИЙН ЦАГААН НИСЭХ БУУДЛЫН ДАРГА ДЭВШӨӨРӨВ 1522030025 2024 оны...дүгээр сарын...-ны өдөр	БАТЛАВ. ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВАРАХ 41 ДҮГЭЭР АНГИЙН ЗАХИРАГЧИЙН АХМАД Б.МӨНХБАТ 2024 оны...дүгээр сарын...-ны өдөр ТТC8430 9065431
 ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ТАРХАЛТЫН ДАДЛАГА, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	
СЭДЭВ: ДЭГЛИЙН ЦАГААН НИСЭХ БУУДЛЫН ЗОРЧИГЧДЫН ТАНХИМД ГАРСАН ГАЛ ТҮЙМРИЙГ УНТРААХ. ХУГАЦАА: 2024 ОНЫ 6 ДУГААР САРЫН 19-НЫ ӨДӨР /60 МИНУТ/ ОБЪЕКТИЙН ХАЯГ, БАЙРШИЛ: ТҮРГЭН СУМ БАЯНХАЙРХАН БАГ ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВАРАХ 41-Р АНГИАС: 15 КМ ШААРДЛАГАТАЙ УТАСНЫ ДУГААР: /ДАРГА 99049939, 70452873, 70452461 /	
ХЯНАСАН: ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ АХЛАХ ДЭСЛЭГЧ Б.МӨНХТУЛГА БОЛОВСРУУЛСАН: ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВАРАХ 41 ДҮГЭЭР АНГИЙН САЛААНЫ ЗАХИРАГЧИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ АХЛАХ АХЛАГЧ А.АЛТАНХҮЯГ	
УЛААНГОМ 2024 ОН	

- **2.Нисэх буудлын орчинд онгоц шувуутай мөргөлдөх**

Нисэх буудлын орчинд агаарын хөлөг шувуутай мөргөлдөх нь маш олон төрлийн хор хөнөөл болоод эдийн засгийн хохирол учруулж болзошгүй байдаг тул нисэх буудлын шувууны хяналтын ажилтан шувуудын бөөгнөрөл болоод нэр төрлөөр нь судалж нүүдэллэн ирэх болон явах хугацааг ч нарийн тодорхойлсон байдаг. Манайд хавар цаг уурын онцлогоос хамаарч 4-р сарын эхнээс шувууд нүүдэллэн ирдэг бөгөөд нисэх буудлын хяналтын цэг орчимд ихэвчлэн элээ, зээрд шонхор, хараацай, хээрийн болжмор, хэрээ, хааяа усны шувууд ажиглагдаж байдаг. Иймд нисэх буудлын шувууны хяналтын ажилтан нислэг бүрийн өмнө аюулгүй байдлыг хангаж шувууны үзлэгт гарч шувууд бөөгнөрч цугларсан бол үргээж агаарын хөлгийг аюулгүй газардуулдаг.

4.Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт.

Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл барилгын ажилаа зогсоож энэ тухай дүүргийн,сумын засаг дарга цагдаагийн болон уг асуудал эрхэлсэн эрдэм шинжилгээний байгуулгад нэн даруй мэдэгдэх гэсэн хуулийн заалт байдаг ба Увс аймгийн Дэглий Цагаан нисэх буудал 2024 онд шинээр барилга байгууламж бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй.

5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилт.

Увс аймгийн Дэглий Цагаан нисэх буудал хог хаягдлын тухай үндэсний болон олон улсын нийтлэг хууль журмыг дагаж мөрдөхөд нийцсэн орчин бүрдүүлнэ. Нисэх буудлын үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилах, өөр дээр түр хадгалахад ****Хог хаягдлын тухай**** хуульд заасан шаардлагад нийцүүлэх бөгөөд хуулийн 7 дугаар бүлгийн 14-р зүйлд заасан ****Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх**** үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ. Нисэх буудалд ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал гардаг ба аюултай хог хаягдал гардаггүй. 2024 оны хавар 5 сард нисэх буудлын уурын зуухнаас гарсан үнс нурмыг өөрийн зардлаар аймгийн төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн асгасан.



Хавар хуримтлагдсан хог хаягдал үнс нурмийг аймгийн төвлөрсөн хогийн цэг рүү тээвэрлэж буй байдал.



Нисэх буудал хог хаягдал, үнс нурмаа тээвэрлэн асгасны дараах байдал.

2024оны төлөвлөгөөний дагуу ангилан ялгах хогийн сав хийх ажил тусгагдсан бөгөөд тус ажилыг хийж гүйцэтгэсэн. Ингэснээр нисэх буудалд хуримтлагдаж байсан ус ундааны хуванцар сав, шил, лааз,гэх мэт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялгаж дахивар бүтээгдэхүүнийг дахин боловсруулах цэгт хүргэсэнээр байгальд үзүүлэх хор хөнөөлийг багасгаж байгаа юм.



Ангилан ялгах хогийн сав.

6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт.

1. Агаарын чанарын NO₂. SO₂. Шинжилгээ хийлгэх.

Увс аймгийн **ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лаборатори**-оор агаарын чанарын шинжилгээ хийлгэсэн.



Агаарын чанарын шинжилгээ хийлгэж байгаа байдал. Шинжилгээг нисэх буудлын уурын зуухны ойролцоогоос хийлгэв.

1.Агаарын чанарын шинжилгээний хариу.



УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Увс аймаг, Улаангом сум, 5-р баг,
Утас: 7045-3680

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дугаар он / код№ 2024/347

Сорьц авсан газрын нэр, хаяг, утас

Сорьц авсан хүний нэр, албан тушаал

Сорьцын хэмжээ, төрөл

Сорьц авсан огноо

Шинжилгээний аргын стандарт

Лабораторид ирсэн

Шинжилгээ хийсэн өдөр

Хуудасны тоо

Үр дүн:

:"Дэглий цагаан" нисэх буудал

: Ж.Сүлд-Эрдэнэ, шинжээч

: агаар,

: 2024.11.04

: MNS, MNS ISO

: 2024.11.04

: 2024.11.04

: 1/1

Шинжилгээний аргын стандартууд	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Хүлцэх өгүүлэмж MNS 4585.2016	Шинжилгээний үр дүн
MNS 17.2.5.12:2021	Хүхэрлэг хий – SO_2 , mg/m^3	0.450	0.002
MNS 17.2.5.11:2021	Азотын давхар исэл – NO_2 , mg/m^3	0.200	0.013
MNS 4048-88	Тоос– нийт, mg/m^3	0.500	0.006

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч

Хянаж баталгаажуулсан чанарын менежер



Ж.Сүлд-Эрдэнэ

(нэр)

Л.ОЮУНЧИМЭГ

(гарын үсэг)

(нэр)

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн сорьцонд хамаарна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

2. Усны чанарын шинжилгээ хийлгэх.



Усны шинжилгээг нисэх буудлын гүний худгаас дээж авч шинжлүүлэв.

Сорьцод 1.5л ус.

2. Усны шинжилгээний хариу.



УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Утас: 7045-3080, Улаангом сум, 5-р баг
Утас: 7045-3080

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дугаар он / код № 2024/345

Сорьц авсан газрын нэр, хаяг, утас : "Дэглий цагаан" нисэх буудал
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Ж.Сүлд-Эрдэнэ, шинжлэгч
Сорьцын хэмжээ, төрөл : ус, 1.5 л
Сорьц авсан огноо : 2024.11.04
Шинжилгээний аргын стандарт : MNS, MNS ISO
Лабораторид ирсэн : 2024.11.04
Шинжилгээ хийсэн огноо : 2024.11.05-07
Хуудасны тоо : 1/1
Үр дүн:

Шинжилгээний аргын стандартууд	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжээ нэгж	Хүлээх агууламж, MNS 900:2018	Шинжилгээний үр дүн
MNS ISO 10523:2001	Усны орчин, pH	6.5-8.5	8.03
MNS 6836:2020	Умбуур бодис, мг/л		5.6
MNS ISO 7888:1999	Цахилгаан дамжуулах чанар /EC/, $\mu S/cm$	1000	381.0
MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар /ПМЧ/, мг/л		0.9
MNS 1097:2023	Аммоний /NH ₄ /, мг/л	1.5	0.04
MNS 4431:2005	Нитрит /NO ₂ /, мг/л	1.0	0.004
MNS 6834:2020	Нитрат /NO ₃ /, мг/л	50.0	0.47
MNS 1097:2023	Сульфат /SO ₄ /, мг/л	500.0	32.9
MNS ISO 6878:2001	Фосфат /PO ₄ /, мг/л	3.5	0.016
MNS 4430:2005	Төмөр /Fe/, мг/л	0.3	0.04
MNS 6272:2011	Фтор /F/, мг/л	0.7-1.5	0.15
MNS 4424:2005	Хлор /Cl/, мг/л	350.0	17.7
MNS 1097:2023	Магний /Mg/, мг/л	30.0	10.7
MNS 6778:2019	Хатуулга, мг-жв/л	7	3.68
MNS 1097:2023	Натрий+кали /Na+K/, мг/л	200	7.6
MNS 6832:2020	Гидрокарбонат /HCO ₃ /, мг/л		170.8
MNS 1097:2023	Кальций /Ca/, мг/л	100	56.1
MNS 6835:2020	Цахиур /Si/, мг/л		12.7


Шинжилгээ гүйцэтгэсэн шинжлэгч

Хянаж баталгаажуулсан чанарын менежер

Ж.Сүлд-Эрдэнэ
ИТГЭМЖЛЭГДСЭН (нэр)
LABORATORY
Л.ОЮУНЧИМЭГ
(орлогч үзэгч) (нэр)

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн сорьцонд хамгаарна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

3.Хөрсний шинжилгээ хийлгэх.



Хөрсний шинжилгээ хийх дээжийг нисэх буудлын шатахууны агуулахын орчиноос 500гр хөрс авав.

3.Хөрсний шинжилгээний хариу.



УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ
Увс аймаг, Улаангом сум, 5-р баг
Утас: 7045-3680

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дугаар он / код № 2024/346
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас : "Дэглий цагаан" нисэх буудал
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Ж.Сүлд-Эрдэнэ, шинжээч
Сорьцон хэмжээ, төрөл : хөрс, 500 г
Сорьц авсан огноо : 2024.11.04
Шинжилгээний аргын стандарт : MNS, MNS ISO
Лабораторид ирсэн : 2024.11.04
Шинжилгээ хийсэн огноо : 2024.11.05-08
Хуудсаны тоо : 1/1
Үр дүн:

Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжээх нэгж	Шинжилгээний үр дүн
MNS 3310:1991	Орчин – pH	8.72
	Давсжилт - EC μS/cm	54.0
	Чийг - %	0.63
	Ялзмаг	1.5
	Аммиак – NH ₄ мг/кг	54.7
	Нитрат – NO ₃ мг/кг	13.2
	Фосфат - PO ₄ мг/кг	3.2
	Сульфат - SO ₄ мг/кг	47.9

Шинжилгээ гүйцэтгэсэн ахлах шинжээч / Б.БАЯРАА / (нэр)
Хянаж баталгаажуулсан чанарын менежер / ОЮУН-ИМЭГ / (нэр)



Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн сорьцонд хамъярна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.